

Судлагдахууны нэр: Хими

Илтгэлийн нэр: “Зэсийг бид амьдралдаа хэрэглэдгийн учир” судалгаат хичээлийн аргазүйн туршлага

Судалгаат хичээлийг явуулсан үндэслэл: хичээлийн судалгааны аргазүйг сайжруулах , сурагчдыг сурах арга барил эзэмшүүлэх, хөгжүүлэхэд тус нэмэр болох, бусдад түгээн дэлгэрүүлэх / сургалт/

Хичээлийн санаа: Энэхүү сэдэв нь металл зэсийн өөрийн **өвөрмөгц шинжийг** судлах, нийгмийн амьдралд түүний гүйцэтгэхтодорхойлуулахыг зорьсон юм.

Хичээлийн судалгааг хийхэд манай сургуулийн “Цогц чадамж “ багийн гишүүд болох: Отгончулуун- англи хэлний багш

Отгонтуяа - орос хэлний багш

Мөнхцэцэг - англи хэлний багш

Туулсайхан - англи хэлний багш

Д. Эрдэнэчимэг- бага ангийн багш

Батцэцэг - бага ангийн багш

Болдсайхан – байрны багш нар хамтран хичээлийн бэлтгэл судалгааг хийсэн . Энэ хичээлийг 2013- 03р сарын химийн багш Д. Энхжаргал 9а ангид заасан. Энэ хичээлээр багуудыг өөр өөр чиглэлээр судалгаа хийлгэж багаар хамтран асуудлын шийдвэрлэж бусад багуудад тайлбаруулах , харилан бие биедээ асуулт тавьж хариулах байсан нь үр дүн муутай явагдсан . Баг зөвхөн өөрийн багийн асуулт даалгавартаа анхаарч бусдыг сонсох, бусдаас гарах санааг тэмдэглэхэд учир дутагдалтай байлаа.

Дараагийн сайжруулан заах хичээлийг сурагчдаар мэдлэг бүтээлгэх аргазүйг өөрчлөн багуудад өгөх нэмэлт мэдээлэл ,ажлын дарааллыг ижил өгсөн.Зэсийн мөн чанарыг 4 баг зэрэг судалж тодорхойлсон , илүү үр дүнтэй байлаа

Сайжруулсан хичээлийг 9б ангид 2013-03 ... хичээлийг зохион байгуулсан.

Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл

Хичээл эхлэхийн өмнө сурагчид 4 багаар хуваагдаж суусан.Энэ ангийн сурагчид өмнөх хичээлээр алт гэдэг химийн элементийн судалгаа хийгдсэн ба/ 1в –бүлгийн элементийн атомын бүтцийн онцлог, физик химийн онцлог ,байгаль орших хэлбэр, олборлолт , байгаль хүний амьдралд үзүүлэх эерэг сөрөг нөлөөлөл

түүнээс хэрхэн сэргийдэхэд бидний оруулах хувь нэмэр зэргийг багаар судлан тогтоосон билээ. Үүгээр дамжуулан 1в –бүлгийн зэсийн өвөрмөгц шинжийг тодорхойлохыг зорьсон.



Хичээлийн эхэнд багш – зэсийн талаар та нар юу мэдэх вэ ? гэсэн асуултыг тавьж бүх сурагчдаас санаа давхардуулахгүйгээр хариултыг амаар нь яриулж бусад нь тэмдэглэгээ хөтөлсөн . дараа нь багш өөрийн сумын музейд байдаг зэсэн эдлэл хэрэгллийн талаарх бичлэг сонирхуулсан .

Багууд яагаад зэсэн эдлэл болон зэс бидний биед хэрэгтэй байдгийн мөн чанарыг олохоор багаараа сурах бичиг ба мэдээлэлтэй танилцаж багууд онцлогийг нээх судалгааг маш идэвхтэй хийсэн.

Багш ширээн дээр 4 аяганд ус хийж тавьсан /мөнгөн, шаазан, зэс, пивор/

Та нар аль аягатай усыг сонгож хэрэглэх вэ? гэсэн асуултад 6 сурагч мөнгө, 24сурагч зэс ,2 сурагч- шаазан пивор аяга сонгогдоогүй/

Өнөөдөр та нар аль аягыг гэртээ хэрэглэдэг --- 23 сурагч шаазан 9 сурагч зэсэн гэсэн хариулт өгч байлаа.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл

Сурагчид өөрсдийн гэрээс авчирсан эд зүйлсийг өгөгдсөн зааврын дагуу ажиглаж, барьж , харж цохиж, хазаж усанд хийх зэргээр судалсан. Багууд дотроо ярилцаж зэсийн мөн чанарыг тодорхойлсон бусдадаа тайлбарласан. Бусад нь анхааралтай сонсож нэмэлт санаагаа гарч тайлбарласан Бусад багийн хариултыг сурагчид дэвтэртээ бичиж тэмдэглэв. Дэлгэцнээс мэдээлэл харуулах

Монголчууд зэсэн аяга сав суулга бугйвч хэрэглэдгийн ,,.,.,.,

Гэрлийн утас хийдгийн....

Зэстэй бүтээгдэхүүн сонгож хэрэглэхийн учир....

Зэс эрэлт хэрэгцээтэй , үнэтэй байдгийн ,,,,

Эх орноороо бахархах хайрлахын учир... гэсэн асуултад сурагч бүр өөрийн хариултаа дэвтэртээ бичиж багаараа санаагаа нэгтгэж багаас нэг сурагч тайлбардана.



Багуудаас гарсан хариулт нь:

- ✓ **Зэс нь металл шинжтэй , давтагдана, сунгагдана, цахилгаан дулаан дамжуулна. Химийн идэвх сул, Өнгөтэй, эрэл хэрэгцээтэй . биоэнергитэй, өвчин анагаах чадвартай , өвчнөөс сэргийлнэ, үнэтэй. Бидний биед агуулагддаг, хүнсний бүтээгдэхүүнд байдаг, эртнээс хэрэглэж ирсэн, манай орон зэсээр баян , зэс бидэнд хоол , мөнгө болон хувирч хэрэглэгддэг элемент юм.гэж багууд ерөнхий санаагаа илэрхийлсэн .**

Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл

Зэс бидний амьдралд хэрэглэгдд



гийн учир нь энэ металлын атомын бүтэц физик химийн шинж чанартай холбоотой болохыг тодорхойлсон. Багуудад зурган мэдээлэл өгсөн ба багийн гишүүд тусгай цаасан дээр санаагаа бичиж наана.

Хөрсөн дор минь ,,,,,, арвин

Яндаж болшгүй далай яасан..... орон бэ?


Хөдөө тал миньдүүрэн сурагчид өөрсдийн бодлоо илэрхийлсэн.

Зэс биднийг анагаана

Зэс биднийг гоёно

Зэс бидний саалийн үнээ

Бид эх орноороо бахархана. Хайрлана.гэж хүүхдүүд дүгнэсэн билээ.



Дүгнэлт

Энэхүү хичээлээс та бүхэнд өгөх санаа бол сурагчдын санааг аль болох бүгдийг сонсох, өөрсдөөр мэдрүүлж хэлүүлэх багт жигд оролцоотой байлгах

Бие дааж сэтгэх, өөрийн санаагаа илэрхийлэх боломж олгоход хугацаа гаргахад анхаарах, багш хүлээцтэй байх хэрэгтэй юм.

Хичээлийн сэдэлжүүлт ба хэрэглэгдэхүүний бэлтгэлд орон нутгийн бололцоог судлаж ашиглахад анхаарах нь зүйтэй.